| 46 | | 1. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний нийт 579 км хатуу хучилттай авто замд их засвар шинэчлэлт хийнэ. | 2021-2024 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 361,900.0 | | **2022 он:** Их засварын ажлыг үргэлжлүүлнэ | 147,532.0 | **АЗБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ:** - Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил, Хүйтний Хөндийгөөс Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засварын ажил, - Зам, тээврийн хөгжлийн Сайдын багцаас Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 53 тэрбум төгрөгийн ажил хэрэгжиж байна. "Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд нийт 311 км хатуу хучилттай авто зам, 1205 м урттай 8 ш төмөрбетон гүүрийг засварлахаар Дэлхийн банканд танилцуулж дэмжигдээд байна. Төсөл 2023 оноос эхлэн хэрэгжинэ. - Налайх-Чойр чиглэлийн 50 км, Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн 90 км,хатуу хучилттай авто замын их засвар ажлын зураг төслийг хүлээлгэн өгсөн. Дархан- | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | | | | | | | | | Алтанбулаг чиглэлийн 113 км автозамыг 4 эгнээ болгон өргөтгөх, Налайх-Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км автозамыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх ажлын зураг төслийг боловсруулсан.<br>2023 оны улсын төсвийн тухай хуульд их засварын ажилд зориулан 35 тэрбум төгрөг батлагдсан. Уг хөрөнгөөр их засварын ажил хийх замуудын жагсаалтыг гаргаж байна. | |
| 47 | | 2.Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний нийт 334 км хатуу хучилттай авто замд ээлжит засварын ажлыг хийнэ. | 2022-2024 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 142,610.0 | - | Ээлжит засварын ажлыг эхлүүлнэ. | 51,100.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:**<br>Ээлжит засварын ажил гүйцэтгэх гадаргуун боловсруулалтын чип сийлэр, сларри сийлэр машинуудыг хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 172 дугаартай тушаалаар баталсан “Улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын 2022 оны төлөвлөгөө”-нд тусгасан “Гол чиглэлийн замуудаас судалгаа хийж сонгож хэсэгчилсэн ээлжит засвар хийх” ажлын хүрээнд гадаргуун боловсруулалтын ажил хийгдэх замын чиглэл, байршил, зарцуулах хөрөнгийн жагсаалтыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.07.08-ны өдрийн А/211 дугаартай тушаалаар баталсан.<br>Тушаалд тусгасны дагуу зам хариуцагч байгууллагууд хариуцсан замд Чип сийл болон Сларри сийлийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: А0301 Улаанбаатар-Арвайхээр чиглэл, А27 Лүн-Дашинчилэн-Батцэнгэл чиглэл, А0501 Улаанбаатар-Өндөрхаан чиглэлд нийт 46,33 км авто замд ээлжит засвар хийсэн. | 100 |
| 48 | | 3.<br>Олон улсын болон улсын чанартай 14,918.7 км авто замын сүлжээнд урсгал засвар арчлалт хийнэ | 2021-2024 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он Улсын төсөв 45,800.0 Замын сан 5,611.2 Нийт 51,411.2 2021 он: Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2021 он Улсын төсөв 30,000.0 Замын сан 5,495.1 Нийт 35,495.1 2022 он: | 427,300.0 | | Арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэнэ. | 102,500.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:**<br>Олон улсын болон улсын чанартай 14918.7 км авто замын урсгал засвар арчлалтын ажлын 2022 оны төлөвлөгөөг замын чиглэл бүрээр, хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчим, эвдрэлийн байдал зэргээс хамаарч зам хариуцагч бүрээр тооцон гаргаж сайдын 2022.01.06-ны А/03 дугаартай тушаалаар батлуулсан.<br>Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу төлөвлөгөөг 2022.02.25-ны А/47 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу зам хариуцагч төрийн өмчит 20 компанитай засвар арчлалтын гэрээг шинэчлэн байгуулж, засвар, арчлалтын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгүүлэн, гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Өдөр тутмын хяналтыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ гүйцэтгэж байна.<br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу зам хариуцагч төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 12 компанитай засвар арчлалтын гэрээг шинэчлэн байгуулж 2022 онд гүйцэтгэх урсгал засвар, | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | арчлалтын ажлын график төлөвлөгөөг баталсан.<br>График төлөвлөгөөний дагуу засвар, арчлалтын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгүүлэн, гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд засвар арчлалтын ажлын гүйцэтгэл 89 хувьтай байна.<br>Урсгал засвар, арчлалтын ажилд техник технологийн өдөр тутмын хяналтын зөвлөх үйлчилгээг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ гүйцэтгэж байна. | |
| 49 | | 4. Авто зам засвар арчлалтын байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлнэ | 2021-2024 | Улсын төсөв, гадаад зээл Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он:<br><br>2022 он: | 69,000.0 | | **2022 он:** Төслийн хэрэгжилт 30 хувьд хүргэнэ | 13,800.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:**<br>Зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дүгээр тушаар батлагдсан “Зам, тээврийн салбарын стратеги төлөвлөгөө”-ний хавсралтаар “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засвар, ашиглалтыг сайжруулж, чадавхийг бэхжүүлэх дэд хөтөлбөр” батлагдсан.<br>Хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 80%-тай, **төслийн хэрэгжилт 45%-тай.** | 100 |
| 50 | | 5. Улаанбаатар - Арвайхээр чиглэлийн 57.56 км хатуу хучилттай авто замын их засварын ажил | 2021-2022 | Гадаад зээл Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он:<br>2021 он: 1,595,928.07USD<br>2022 он: 4,387,543.84 USD | 43,120.0 | | **2022 он:** Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувь | 25,872.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:**<br>Барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийн хүрээнд 2022 оны барилгын ажлын төлөвлөгөөг баталсан. Мөн гадаадаас авах ажиллах хүчний зөвшөөрлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Гадаадын иргэн, харьятын газраар гаргуулсан. Барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг Замын-Үүд хилийн боомтоор саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авсан.<br>Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 81.23%-тай байна. “Хүйтний хөндий -Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын их засвар болон гүйцэтгэлд суурилсан засвар арчлалтын ажил”-ын “Гэрээний ерөнхий нөхцөл”-ийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу хэсэгчлэн байнгын ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 81.23 / 100 *100=<br><br>81.2 |
| 51 | | **3.6.2.2. Онги, Түргэн, Байдраг, Хэрлэн, Ерөө, Орхон, Гичгэнэ, Чигэстэй голуудын нийт 1306.8 урт метр төмөр бетон гүүрэнд их засварын ажлыг хийнэ.** | | | | | | | | |
| | | 1. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Онгийн голын 166 у/м төмөр бетон гүүр | 2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 1,180.0 | - | Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувь | 1,180.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:**<br>**МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт тусгагдаагүй.**<br>Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Хүйтний Хөндийгөөс Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засварын ажлын хүрээнд тус гүүрний засварыг хэрэгжүүлэхээр болсон. Гэвч Зураг зохиогч Ар Си Эс Си ХХК болон гүйцэтгэгч Эйч Кэй Би ХХК, орон нутаг, төсөл хэрэгжүүлэх нэгж, Захиалагч, зөвлөх Ай Си ТИ сайн консалтинг ХХК нар хамтран гүүрэнд үзлэг хийсэн бөгөөд үзлэгээр гүүрийг АХБ-аас тавигдсан хөрөнгөөр бүрэн засварлах | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | боломжгүй болсон. Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тус гүүрэнд их засвар шинэчлэлт хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан. | |
| 52 | | 2. Увс аймгийн Түргэн сумын Түргэний голын 160.8 у/м төмөр бетон гүүр | 2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 2,360.0 | - | Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувь | 2,360.0 | **АЗБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ:** **МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт тусгагдаагүй.**. Санхүүжилтийн эх үүсвэрийг 2023 оны Улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна | - |
| 53 | | 6. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөөгийн голын 192 у/м төмөр бетон гүүр | 2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 3,450.0 | - | Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувь | 3,450.0 | **АЗБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ:** **МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт тусгагдаагүй.** Санхүүжилтийн эх үүсвэрийг 2023 оны Улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна. | - |
| 54 | | 7. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны голын 290 у/м төмөр бетон гүүр | 2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 5,220.0 | - | Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувь | 5,220.0 | **АЗБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ:** **МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт тусгагдаагүй.** Их засварын ажлын зураг төслийг боловсруулж хүлээлгэн өгсөн. Дэлхийн банкны "Монгол Улсын зам тээврийн холболт ба логистикийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд уг гүүрийг засварлахаар саналаа хүргүүлсэн. Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. | - |
| | | **3.6.2.3. Авто замын ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, төлбөр хураах цэгийн тоог нэмэгдүүлж бүрэн цахимжуулна.** | | | | | | | | |
| 55 | | 1. Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгийг цахимжуулах, Мөрөн, Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчимд төлбөр авах цэг байгуулна. | 2021-2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 4,580.0 | Төлбөр авах цэг 4 цахимжсан | **2022 он:** Төлбөр авах 14 цэгийг цахимжуулна, 4 төлбөр авах цэг шинээр баригдана | 3,308.0 | **АЗБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Сайншанд /Чойр цэгийн оронд/, Өмнөговь аймгийн Даланзадгад хотод тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөн дунд даац хэмжих автопүү бүхий ухаалаг, цахим төлбөр авах цэг барихаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/55 дугаар тушаалаар хөрөнгө баталж, ажлын даалгавар боловсруулсан. Тендер шалгаруулалт зарласан боловч оролцогч ирээгүй тул тендер хүчингүй болсон. Дээрх цэгүүдэд 2023 онд төлбөр авах цэг барихаар төлөвлөж байна.<br>Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төлбөр авах цэгийн үйл ажиллагааг 2022.08.17-ны өдөр эхлүүлсэн.<br>2022 онд Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 2022.01.05, Ховд аймгийн Манхан суманд 2022.09.18-нд шинээр төлбөр авах цэг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн.<br>Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Налайх, Хоолт, Түргэний гүүрийн төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахимжуулж, тээврийн хэрэгслийг дугаарыг бүртгэж, шууд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна. | 30 |
| 56 | | 2. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын орчимд төлбөр хураах цэг байгуулна | 2021 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 760.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь | Ажлын гүйцэтгэл 100% | 760.0 | **АЗБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ:** Хөрөнгийг 2022 оны засвар арчлалтын ажлын төлөвлөгөөнд тусган батлуулсан.<br>Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төлбөр авах цэгийг ашиглалтад оруулж, 2022.08.17-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | | 3. Олон улс, улсын чанартай авто зам дээр одоо байгаа төлбөр авах цэгт төлбөрийн цахим систем нэвтрүүлнэ | 2021-2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 1,280.0 | 4 ТАЦ | **2022 он:** Төлбөр авах 15 цэгийг цахимжуулна | 768.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:** Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Налайх, Хоолтын төлбөр авах цэгт тээврийн хэрэгслийн дугаар таних камер, тоног төхөөрөмжийг суурилуулж, урьдчилж төлөх, төлбөр авах цэгээр нэвтрэх үед төлөх, дараа төлөх гэсэн 3 сонголтоор “Monpay” “Social pay” “E-баримт” үйлчилгээг ашиглан цахимаар төлбөр авах үйл ажиллагааг нэвтрүүлсэн. Цахим системийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төлбөр авах цэгүүдэд суурилуулж программ хангамж холбох ажлыг үе шаттай хийж байна. | 30 |
| 58 | | 4. Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчинд төлбөр авах цэг байгуулна. | 2022 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2022 он: | 2,540.0 | - | 4 төлбөр авах цэг барьсан байна | 2,540.0 | **АЗБХЗГ, “ЗТХТ” ТӨҮГ:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Сайншанд /Чойр цэгийн оронд/, Өмнөговь аймгийн Даланзадгад хотод тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөн дунд даац хэмжих автопүү бүхий ухаалаг, цахим төлбөр авах цэг барихаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/55 дугаар тушаалаар хөрөнгө баталж, ажлын даалгавар боловсруулсан. Тендер шалгаруулахаар ажиллаж байна.<br>Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төлбөр авах цэгийг ашиглалтад оруулж, 2022.08.17-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн.<br><br>, Даланзадгад сумдад “ухаалаг төлбөр авах цэг” барих тендер зарласан боловч хүчингүй болсон. Хяргас нуур, Сүхбаатар Түмэнцогт төлбөр авах цэг барих хөрөнгө батлагдаагүй тул энэ жил хэрэгжих боломжгүй болсон. | 30 |
| | 3.6.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ: 2 3 | **3.6.3.1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг цахилгаан болон байгалийн шатдаг хийгээр ажилладаг хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэлд бүрэн шилжүүлэн, цахилгаан болон байгалийн шатдаг хийгээр цэнэглэх сүлжээг бий болгоно** | | | | | | | | |
| 59 | | 1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. | 2021-2024 | Концессын гэрээ Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 390,000.0 | - | **2022 он:** Цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц | 108,000.0 | **АТБХЗГ, "АТҮТ" ТӨҮГ:** 2021 онд **23 цахилгаан автомашин цэнэглэх цэг байгуулан ашиглаж байна. Хийгээр цэгэлэх 4 байгууламжийг барьж ашиглалтад оруулсан.**<br>2022 онд Улаанбаатар хотод цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 4, Хэнтий аймагт 3, Өмнөговь аймагт 7, нийт 14, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх станц орон нутагт 1, УБ хотод 4, нийт 5-ыг байгуулсан. Улсын хэмжээнд 20-60 квт-ийн хүчин чадалтай цахилгаан автомашин цэнэглэх 25, өндөр хүчин чадалтай их багтаамжийн цахилгаан автобус цэнэглэх 11, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх 21 аймагт 80, УБ хотод 54 станц байгуулж ашиглаж байна. Нийслэлийн 8 байршилд шинээр өндөр хүчин чадалтай цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 25 станц барих санхүүжилтийг 2023 оны Агаар, орчны бохирдлыг бууруулах сангийн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **3.6.3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэл болон орон нутагт ачаа, зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна.** | | | | | | | |
| 60 | | 1. Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Орхон, Говь-Сүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал байгуулна; | 2021-2024 | Концессын гэрээ, Улсын төсөв, төр хувийн хэвшлийн түншлэл Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 27,500.0 | - | **2022 он:** 3 аймгийн автобуудал ашиглалтад оруулна. | 7,500.0 | **АТБХЗГ, АТҮТ:**<br>1. Улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймагт автобуудал барих төсөл хэрэгжиж байна. Автобуудлын барилга угсралтын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөний дагуу хоцрогдолгүй явж байна.<br>2. “Зорчигч тээврийн Ховд” ХХК нь компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85%-тай, энэ онд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна.<br>3. “Бүрд чандмань” ХХК Хэнтий аймгийн Хэрлэн сумд автобуудал, мөн “Гэзэгт” ЗГБХН-ээс Говьсүмбэр аймгийн төвд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа байранд өргөтгөл хийж автобуудал байгуулах санал, ТЭЗҮ ирүүлснийг хэрэгжих боломжтой гэж үзэн хамтран ажиллах гэрээ байгуулсан. | 50 |
| 61 | | 2. Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Ханбогд Гашуунсухайт боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулна | 2021-2023 | Концессын гэрээ Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 38,750.0 | - | **2022 он:** Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь | 15,550.0 | **ТЗДТБХЗГ, БТГ, АТБХЗГ, "АТҮТ" ТӨҮГ, "МТЗ" ТӨХК:**<br>Гашуунсухайт боомтод үерийн далан, чингэлэг тээвэр, урт болон богинын тээврийн зам талбайн ажил хийгдэж, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна. **Жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай уг терминал 2021.09.20-нд ашиглалтад орсон.**<br>Өмнөговь аймгийн Цогтцэций сумaнд Холимог тээврийн логистикийн төвийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 800 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг 2021.11.24-ны өдрийн 01/5304 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн.<br>Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 2-ны өдрийн 185 дугаар тогтоолын хүрээнд **Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын Алт” ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.**<br>Тавантолгой холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгө шийдэх чиглэлээр "Эрдэнэс таван толгой" ХК дээр ажлын хэсэг байгуулагдсан. Тавантолгойн холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ-г боловсруулж логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл” ХХК ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 40%-тай явагдаж байна. | 100 |
| | | **1. Олон улсын нислэгийг өргөжүүлэх, аяллын дугаар хуваах зэргээр нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 62 | 3.6.4. Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна | 1. Агаарын харилцааны зохицуулалтыг сайжруулж, агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг байгуулна. | 2021-2024 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 2,300.0 | - | **2022 он:** 4 улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулж, 1 улстай нислэгийн цэг, давтамжийг нэмэгдүүлсэн байна. | 600.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:**<br>Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд байгуулах Агаарын тээврийн тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, Протокол үйлдсэн. Хэлэлцээрийн төсөлд яамдаас санал авсан /2022.10.27-ны 01/4945/. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.<br>Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хооронд байгуулах Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, 2022.10.21-ний өдөр үзэглэсэн. Хэлэлцээрийн төсөлд яамдаас санал авахаар бэлтгэж байна.<br>БНЛаосУ, БНУзУ-тай Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төсөл эцэслэн тохиролцсон, үзэглэхээр айлын талын боломжит хугацааг хүлээж байна.<br>БНСлоУ, БНИтУ-тай Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төсөл дипломат шугамаар солилцсон, ИБУИНХУ-тай Агаарын харилцааны тухай хэлэлцээр шинэчлэн байгуулахаар хэлэлцээрийн төсөл солилцсон, ICAN2022 арга хэмжээний үеэр үзэглэхээр бэлтгэл хангаж ажиллаж байна.<br>**Нислэгийн цэг, давтамж нэмэгдүүлэх:**<br>Монгол-Япон хоорондын нислэгийн давтамж долоо хоногийн 13 хүртэлх давтамж байсныг 9000 суудлын багтаамж, 30 хүртэлх давтамж болгон нэмэгдүүлсэн. Ингэснээр тухайн чиглэлд жилд 1,872,000 суудал нийлүүлэх боломжтой болсон.<br>БНХАУ-тай байгуулсан Иргэний агаарын тээврийн тухай хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон Далиан нислэгийн цэгийг Шэньжэнь цэгээр солихоор айлын талтай хэлэлцэж байна. | 70 |
| 63 | | 2. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ | 2021-2023 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он 547.8 2021 он: 2022 он: | 51,400.0 | Хөтөлбөр батлагдсан | **2021 он:** Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | 12,850.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:**<br>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.<br>- “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар 78.8%, “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн хэрэгжилт 68%-тай.<br>Тус 2 хөтөлбөрийн эцсийн тайланг 2022 оны эхний улиралд ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Хүчингүй болгосон дээрх 2 хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан байсан зорилт, арга хэмжээнүүдийг Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тусгуулахаар ЗГХЭГ-ын даргын 2021 оны 50 дугаар тушаалаар байгуулсан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна. | |
| 64 | | 3. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийг барьж, дуусган ашиглалтад оруулна | 2020-2021 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2011-2018 онд 15,400.0 2020 он- 2021 он: 2022 он: | 3,900.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 90% | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | 3,900.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:**<br>Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын маргаантай асуудал шүүхийн шатанд үргэлжилж байна. Шүүх хурлаас барилгын үнэлгээ хийлгэхээр хөндлөнгийн шинжээчээр томилсон “Хөрөнгийн үндэсний төв” ХХК-ийн үнэлгээ, дүгнэлт 2022.03.01-ний өдөр гарч, шүүхэд ирүүлснийг нэхэмжлэгч тал буюу ИНЕГ-аас эс зөвшөөрч, гомдол гаргасан. Гомдлыг 2022.03.23-ны өдөр шүүх хянан хэлэлцэж, “Хөрөнгийн үндэсний төв” ХХК-д дүгнэлтийг шаардлага хангуулан 2022.05.17-ны өдрийн дотор дахин ирүүлэхийг даалгасан боловч одоогоор дүгнэлт ирүүлээгүй тул дахин шинжээч томилуулахаар ажиллаж байна.<br>Зам, тээврийн хөгжлийн яамнаас гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас салбарын эрх ашгийг олон жил, ноцтой хохироож буй “Үүрэг Трэйд” ХХК-ийг “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэх саналыг 2022.05.27-ны 03/2430 тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн. БНХУТ-ийн А, Д блок, дэд өртөөний ажлуудыг хэсэгчлэн ашиглалтад оруулахаар гүйцэтгэгч компанид шаардлага тавин ажиллаж байна. | 50 |
| 65 | | 4. Агаарын навигацийн үйлчилгээний техник технологийг шинэчлэнэ. | 2021-2024 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 35,080.0 | | **2022 он:** АТМ тогтолцоог шинэчлэлийг үргэлжлүүлнэ | 7,300.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:**<br>Агаарын навигацийн үйлчилгээний техник технологийг шинэчлэх ажлын хүрээнд Нислэгийн ярианы бичлэгийн системийг нийлүүлж, суурилуулах 1 иж бүрдэл /Баянхонгор/, 33.0 сая төгрөгийн өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202019/01/01 дугаартай тендерийг 2022.03.01-ний өдөр зарлаж, шалгарсан “Комплекс сити” ХХК-тай, бараа нийлүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2022.05.09-ний өдөр тоног төхөөрөмжийг хүлээн авсан.<br>-Агаарын навигацийн холбооны станцуудыг баталгаажуулах хэмжүүрийн багаж нийлүүлэх 2 иж бүрдэл /Баруун, зүүн бүс/-240.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202020/01/01 дугаартай тендерийг 2022.03.02-ны өдөр зарлаж, шалгарсан “BLUE VIEW” ХХК-тай бараа нийлүүлэх гэрээг 2022.04.26-ны өдөр байгуулсан. Хэмжүүрийн багажийг гэрээний хугацаанд хүлээн авсан.<br>-Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн аэродромын дадлагажуур /Улаанбаатар/-3.0 тэрбум /энэ онд санхүүжих дүн 1.0 тэрбум төгрөг/ төгрөгийн өртөг бүхий ажлын | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202021/01/01 дугаартай тендерийг 2022.03.02-ны өдөр зарлаж, 2022.04.01-ний өдөр нээсэн боловч шаардлага хангасан оролцогч оролцоогүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тендерийг дахин зарлаагүй.<br>-Агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийн тэжээлийн системийн батарей 436 ширхэг /УБ,Төв, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор/ 238.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202018/01/01 дугаартай тендерийг 2022.03.01-ний өдөр зарлаж, худалдан авалтыг амжилттай хийсэн.<br>Мөн Монгол Улсын агаарын зайн дээд, доод агаарын замуудыг нэгтгэж уламжлалт (чиг шулуун) агаарын зам 33, үзүүлэлтэд тулгуурласан (RNAV-5) агаарын зам 16 нийт 49 агаарын замыг 2022.10.06-ны өдрөөс ашиглаж эхэлсэн.<br>Агаарын навигацийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ (VPN)-ний тоног төхөөрөмжийг орон нутаг болон алслагдсан байгууламжуудад нийт 24 байрлалаас 15 байрлалд суурилуулсан. Монгол Улсын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ажиглалтын удирдлагатай 4 сектор, процедур удирдлагатай 2 сектор ашиглаж байсныг 2022.10.06-ны өдрөөс ажиглалтын удирдлагатай 5 сектор, процедур удирдлагатай 1 сектор болгож шинэчилсэн. | |
| | | **2. Ховд, Дорнод, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудыг 4 С ангиллын олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх төслийг эхлүүлнэ.** | | | | | | | | |
| 66 | | 1. Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улсын төсөв, гадаадын зээл, тусламж Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 62,000.0 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн | **2022 он:** Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь | 21,000.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:**<br>Чойбалсан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Төслийн зардал, үр ашгийн тооцоог 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотоор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Чойбалсан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>Чойбалсан нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах- | 30 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | | | | | | | | | шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж байна. Мөн “Жайка” ОУХАБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Чойбалсан” нисэх буудлыг 4С ангиллын болгож, ашиглалтыг сайжруулах төслийн нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж байна. | |
| 67 | | 2. Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 44,892.0 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн | **2022 он:** Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь | 9,976.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:** Ховд нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Төслийн зардал, үр ашгийн тооцоог 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотоор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>Ховд нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>Ховд нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-р 2022.03.14-ний өдөр олон улсын нисэх буудал гэж зарласан.<br>Ховд нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, “Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. | 30 |
| 68 | | 3. Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2022 | Гадаадын зээл, тусламж Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 19,440.0 | | **2022 он:** Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь | 9,450.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:** Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Концессын зүйлийн жагсаалтад тусгах бэлтгэл ажлыг хангах хүрээнд төслийн зардал, үр ашгийн тооцоог боловсруулж, 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотоор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>Мөн Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн | 30 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>Мөрөн нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхтгэл (AIP)-ээр 2022.04.07-ны өдөр олон улсын нисэх буудал хэмээн зарласан.<br>Мөрөн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4C ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. | |
| 69 | | 4. Увс аймгийн “Дэглий цагаан” нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг олон улсын 4C ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 61,073.1 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн | **2022 он:** Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 18,321.9 | **ИНБХЗГ, ИНЕГ:**<br>“Дэглий цагаан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн.<br>Мөн Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны “Агаарын замын хилийн боомтын асуудлаар авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Дэглий цагаан нисэх буудалд агаарын замын хилийн боомт шинээр байгуулах асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.02.25-ны өдрийн 01/904 тоотоор Сангийн сайд бөгөөд Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дарга Б.Жавхланд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд Дэглий цагаан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, мөн агаарын замын олон улсын боомт байгуулах асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд танилцуулсан.<br>Дэглий цагаан нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4C ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. | 30 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 70 | | 5. Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромд их засвар хийнэ | 2021-2022 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 900.0 | - | **2022 он:** Хэнтий аймгийн Дадал нисэх буудлуудын аэродромын их засварын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ | 300.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:** *Ховдын Булган сумын нисэх буудлын их засвар:* Ховдын Булган сумын нисэх буудлын аэродромын их засварын ажлын санхүүжилт төсвийн хэмнэлтийн горимын улмаас 2022 оны төсөвт суугаагүй тул уг ажлыг энэ онд гүйцэтгэх боломжгүй болсон. *Хэнтийн Дадал сумын Дэлүүн болдог нисэх буудлын их засвар:* ЗТХ-ийн сайд, Сангийн сайдын 2022.01.21-ний А/17/16 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан ИНҮТ-ийн өөрийн орлогоос санхүүжих 2022 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад Дэлүүн болдог нисэх буудлын хөөрч буух шороон зурвас, агаарын хөлгийн зогсоолын засварын ажилд 422,7 сая төгрөгийн санхүүжилт тусгасан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202006 дугаартай тендерийг 2022.03.04-ний өдөр зарласан, 2022.04.18-ний өдөр нээж гэрээ байгуулах эрх олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хүчингүй болгосон. | - |
| 71 | | 6. Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засвар | 2020-2021 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2021 он: 2022 он: | 980.0 | - | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | 980.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:** Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2022.01.21-ний А/17/16 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан ИНҮТ-ийн өөрийн орлогоос санхүүжих 2022 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад Баянхонгор нисэх буудлын хөөрч, буух хучилттай зурвасын их засварын ажилд 1,099,1 сая төгрөгийн санхүүжилт тусгасан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202009 дугаартай тендерийг 2022.03.02-ны өдөр зарлаж, 2022.04.05-ны өдөр нээж үнэлэхэд шаардлага хангасан оролцогч шалгараагүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу дахин тендер зарлаагүй. | - |
| 72 | | 7. Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийг хэрэгжүүлж дуусгана. | 2020-2022 | Гадаадын зээл, тусламж Зарцуулсан хөрөнгө 2020 он- 2,395.8 сая төг 2021 он: 761.8 сая төг 2022 он: | 8,090.0 | Барилгын гүйцэтгэл 52 хувь | **2022 он:** Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | - | **ИНБХЗГ, ИНЕГ:** Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төслийн Багц 1 буюу зорчигч үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ЗТХЯ/202201070 дугаартай тендерийг 2022.02.07-ны өдөр зарласан. Тендерт шалгарсан "Барилга эрч" ХХК-тай 2022.05.02-ны өдөр Ажил гүйцэтгэх 164 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээгээр гүйцэтгэгч барилгын ажлыг 2023.04.30-ны өдрийн дотор ашиглалтад оруулах үүрэгтэй. 2022.11.22-ны өдрийн байдлаар барилгын ажлын гүйцэтгэл 35.4%-тай байна. Багц 2 буюу аэродромын ажлын гүйцэтгэл 98%-тай байна. | 70 |
| 73 | | 8. Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх буудлыг | 2020-2021 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө | 5,000.0 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | 5,000.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:** Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэл 51%-тай байна. ТНБД-ын 2022.08.11-ний өдрийн | 51 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барьж, дуусган ашиглалтад оруулна. | | 2020 он-<br>2021 он: 4,000.0<br>2022 он: | | | | | А/101 дугаар тушаалаар гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийг 3 талын төлөөллийг оруулан байгуулсан, ажлын хэсгээс гэрээний хугацааг 2023.06.15-ны өдрийг хүртэл сунгаж, үлдэгдэл ажлыг гүйцэтгүүлэх санал гаргасны дагуу 2022.10.06-ны өдөр 288 дугаар нэмэлт гэрээг байгуулж, гэрээний хугацааг сунгасан. | |
| | | **3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна.** | | | | | | | | |
| 74 | | 1. Орон нутгийн зорчигч тээврийн автобуудал, нисэх буудал, төмөр замын буудлын үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг дээшлүүлнэ | 2021-2022 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө<br>2020 он-<br>2021 он:<br>2022 он: | | | **2022 он:** Төслийг дуусгана | | **БТГ, ИНБХЗГ, ИНЕГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ:** Автотээвэр, төмөр замын тээвэр, иргэний агаарын тээврээр олон улс болон дотоодод зорчих “Зорчигчийн нэгдсэн тасалбарын систем”-ийг Tapatrip компанитай хамтран хөгжүүлсэн. Энэхүү системийг нэвтрүүлснээр зорчигчид заавал билетийн касс орохгүйгээр, олон янзын систем ашиглахгүйгээр зөвхөн Tapatrip гэсэн аппликейшн ашиглан, нэг цонхоор бүхий л тээврийн хэрэгслийн тасалбараа нэгэн дор захиалах боломж бүрдсэн. “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-ыг Интерактив ХХК-тай хамтран хөгжүүлж байна. Энэхүү платформ дээр автотээвэр, төмөр замын тээвэр, иргэний агаарын тээврийн зорчигчид хаанаас хаашаа зорчиж буй тоо, зорчигч эргэлтийн мэдээллийг холбогдох бусад системүүдээс веб сервисээр татан авч, нэгдсэн цахим хяналтын самбарт өдөр, сар, улирал, жилээр графикаар гарган, бодлого төлөвлөлтдөө ашиглах боломжийг бүрдүүлж байна. | 70 |
| 75 | | 2. Томоохон сум, суурин газруудад ерөнхий зориулалтын агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас, вертодром барих ажлыг эхлүүлнэ | 2020-2022 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө<br>2020 он-<br>2021 он:<br>2022 он: | 1,800.0 | 30 хөөрч буух зурвас баригдсан | **2022 он:** 10 хөөрч буух зурвас барьж дуусгана. | 600.0 | **ИНБХЗГ, ИНЕГ:** Энэ онд нийт 17 аймгийн 59 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч, буух зурвас сонгон баталгаажуулахаар төлөвлөн ажиллаж буй бөгөөд 2022.11.22-ны өдрийн байдлаар нийт 50 байршилд зурвас сонгоод байна. Мөн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Скай Резорт" ХХК-ийн цанын бааз, "Интермед" эмнэлэг, “River garden” хотхонд, 23 давхарт нисдэг тэрэг хөөрч, буух талбайн (вертодром) үзлэг шалгалт хийж мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан. | 50 |
| 76 | | 3. Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг эхлүүлж, байнгын ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтворжуулсан байна. | 2021 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө<br>2020 он-<br>2021 он:<br>2022 он: | | Барилгын ажлын гүйцэтгэл 100% | Тогворжуулсан байна. | | **ИНБХЗГ:**<br>“Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг 2021.07.04-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан тус буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах нэгдсэн төлөвлөгөөг 2021.04.09-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн сайд баталсан. Төлөвлөгөөнд 4 бүлэг, нийт 143 ажил тусган хэрэгжүүлж дууссан. Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг 2021.07.03-ны өдрөөс эхлүүлсэн.<br>Шинэ нисэх буудал ашиглалтад орсонтой холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.07.09-ний өдрийн “Чингис хаан” олон | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | улсын нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай 06 дугаар албан даалгаврыг баталж, олон улс, орон нутгийн нислэгийг тогтворжуулах, аюулгүй ажиллагааны хангалтыг сайжруулах, нисэх буудлыг гамшиг, цаг уурын болзошгүй эрсдэлээс сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийг баримтлан ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Нисэх буудлын үйл ажиллагаа тогтворжсон. | |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **4.2. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.** | | | | | | | | | | |
| 77 | 4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021-2024 | - | | Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна | | **ТЗУГ:**<br>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын хөтөлбөр”-ийн дагуу яамны удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын мэдлэг чадвар, манлайллыг хангах зорилгоор жил бүр сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдыг 2022 онд сургах сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 24 төрлийн сургалтад давхардсан тоогоор яамны 410 албан хаагч хамрагдсан.<br>Үүнээс мэргэшүүлэх сургалтад 19 бусад сургалтад 364, дотоодын их дээд сургуулийн доктор 1, бакалаврын сургалтад-9 гадаадын их дээд сургуульд-4 албан хаагч суралцаж байна.<br>Ажлын байран дахь сургалт “Мэдээллийн цаг”-ийг 12 удаа зохион байгуулж нийт албан хаагчдыг тухай бүрд хамруулсан.<br>Сургалтад хамрагдсан нийт албан хаагчийн 23 удирдах ажилтан, 360 гүйцэтгэх, туслах албан тушаалтан хамрагдсан байна. Төрийн албаны зөвлөлөөс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”, “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төсөл тус яамнаас эхлэн хэрэгжих болсонтой холбогдуулж сүүлийн 3 жилд шинээр томилогдсон 16 албан хаагчдад “Ёс зүйн сургалт”-ыг зохион байгууллаа. | 100 |
| **4.3. Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.** | | | | | | | | | | |
| 78 | 4.3.10.Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины | 1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, | 2021-2024 | | | - | Гэмт хэрэг, зөрчил болонзам тээврийн осол,түүнээс үүсэх хор уршиг | | **БТГ:**<br>“Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага. MNS 4598:2003” стандартад **“Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх”** | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | камертай байх стандартыг тогтоож, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна. | Автотээврийн тухай, Автозамын тухай, Зөрчлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. | | | | | тодорхой хэмжээгээр буурсан байна | | **талаар холбогдох заалтыг тусгаж батлуулсан.**<br>2021 онд МУ-д 128016 автомашин бүртгэлтэй, зам, тээврийн осол 22482 гарсан. 1 машинд ногдох ЗТО-0,0182 байна.<br>2022 оны 9 дүгээр сарын байдлаар МУ-д 1280216 автомашин бүртгэлтэй, зам, тээврийн осол 15006 гарсан. 1 автомашинд ногдох ЗТО-0,0117 болж буурсан байна. | |
| **5.1.Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 79 | 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна. | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана. | 2020-2024 | | | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг ЗГ-ын 2019 оны 407 дугаар тогтоолоор баталсан. | Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрсхүчлийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна | | **БТГ:**<br>Уур амьсгалын үндэсний хорооны 2021 оны 01/21 дүгээр тогтоолоор баталсан “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.8.2-т ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх “Нүүрс экспортлох тээврийг автотээврээс төмөр замын тээвэрт шилжүүлэх” арга хэмжээг 2022 онд Таван толгой–Гашуунсухайт”-ын барилгын гүйцэтгэл 100% хэрэгжсэн байна гэж тусгасан.<br>Барилгын ажлын явц:<br>Доод бүтцийн ажлын гүйцэтгэл:<br>- Нийт газар шорооны ажил 100%,<br>- Гүүрний ажил 100%,<br>- Ус өнгөрүүлэх хоолойн ажил 100%,<br>Дээд бүтцийн ажлын гүйцэтгэл:<br>- Дээд бүтэц угсрах ажил 100%,<br>- Төслийн хэмжээнд хүргэж өргөж чигжсэн 100%<br>- Эрчим хүчний ажил 98%<br>- Өртөө зөрлөгийн барилгын ажил 91%<br>- Дохиолол холбооны ажил 100%<br>Төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 93.67 хувьтай байна.<br>Техникийн комисс 2022.09.05-07-ны өдрүүдэд ажилласан.<br>Тус төмөр замыг 2022 оны 12 дугаар сард багтаан барилгын ажлыг бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | |
| 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ. | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 80 | 6.1.12. Богдхан төмөр замын төслийг түшиглэн “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. | Богдхан төмөр замын төслийг түшиглэн “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. | 2021-2024 | | | | Судалгаа хийнэ | | **БТГ:** Тус компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022.01.11-ний өдрийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж, Дэд зөвлөл, Зөвлөлийн гишүүдээс гаргасан холбогдох саналыг судалгааны тайланд тусгахаар зааж, дэмжсэн бөгөөд Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор төмөр замын чигийг баталсан. | 90 |
| | **Нийт** | | | | | | | | | **75.7** |